



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/182

Зуунмод

Өвс, ногоон тэжээлийг
хуваарилан олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Засгийн газрын 2023 оны 279 дүгээр тогтоолуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал аж ахуйн хаваржилтыг хүндрэл багатай даван туулах, мал төллөлтийн үеийн эрсдэлийг бууруулахаар аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд бэлтгэсэн 3000 боодол өвсийг нэг бүрийн үнийг 12,000 төгрөгөөр, 2400 боодол ногоон тэжээлийн үнийн дүнг 50%-иар хямдруулан нэг бүрийн үнийг 10,000 төгрөгөөр өндөр эрсдэл бүхий сумдад олгох хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Хуваарилагдсан өвс, ногоон тэжээлийг өөрсдийн зардлаар татан авч малчдадаа хуваарилан ажиллахыг сумдын Засаг дарга нарт, сумдад нийлүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Н.Гантулга)-т тус тус үүрэг болгосугай.

3. Өвс, ногоон тэжээлийн чанар, стандартад хяналт тавьж ажиллахыг мал үржлийн хяналтын Улсын байцаагч (Х.Түвшинсанаа)-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Д.Саран-Эрдэнэ)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/182 дүгээр захирамжийн хавсралт

СУМДАД ОЛГОХ ӨВС, ТЭЖЭЭЛИЙН ХУВААРЬ

№	Сумдын нэр	Өвс /боодол/	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Ногоон тэжээл /боодол/	Нэг бүрийн үнийг 50 хувь хямдруулсан дүн /төгрөг/	Нийт дүн	Байршил
1	Аргалант			200	10000	2000000	Аргалант
2	Алтанбулаг			200	10000	2000000	Аргалант
3	Батсүмбэр			200	10000	2000000	Аргалант
4	Баянчандмань			200	10000	2000000	Аргалант
5	Баянцогт			100	10000	1000000	Аргалант
6	Баян-Өнжүүл	300	12000			3600000	Зуунмод
7	Баянцагаан	300	12000			3600000	Зуунмод
8	Баянжаргалан	250	12000			3000000	Зуунмод
9	Баян	250	12000			3000000	Зуунмод
10	Баянхангай			200	10000	2000000	Аргалант
11	Баяндэлгэр	250	12000			3000000	Зуунмод
12	Борнуур			200	10000	2000000	Аргалант
13	Бүрэн	200	12000	200	10000	4400000	Зуунмод, Аргалант
14	Дэлгэрхаан	250	12000			3000000	Зуунмод
15	Лүн	200	12000			2400000	Зуунмод
16	Заамар			200	10000	2000000	Зуунмод
17	Угтаалцайдам			200	10000	2000000	Зуунмод
18	Өндөрширээт	200	12000			2400000	Зуунмод
19	Сэргэлэн	250	12000			3000000	Зуунмод
20	Эрдэнэ	250	12000			3000000	Зуунмод
21	Эрдэнэсант	300	12000			3600000	Зуунмод
22	Зуунмод			500	10000	5000000	Аргалант
	НИЙТ	3000	12000	2400	10000	60000000	